



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/171/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол Шинжлэх Ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АШБ	Анхан шатны баримт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НХМ	Нэг хэвийн маягт



ДОРНОГОВЬ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.12.23 № 4-6/72

танай _____ -ны № _____ -г

САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ТАВДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
3.МӨНГӨНБАГАНА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн ЗДТГ-аас 75.0 сая төгрөгийн 22 ширхэг зөөврийн компьютер, хандиваар 5.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 68.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын цалингийн зардал 1,581.8 сая төгрөг бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 1,485.7 сая төгрөгөөр, татварын байгууллагад 1,480.4 сая төгрөгөөр тус тус тайлагнасан. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 442.5 сая төгрөгийн 22 гүйлгээг байршуулсан ба орлогын нийт 2,379.1 сая төгрөгийн 66 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулах тушаал, шийдвэрийг шилэн дансны цахим системд огт байршуулаагүй байна.

Өмнөх оны аудитыг Есөнхангай аудит ХХК гүйцэтгэж тус аудитаар 28.4 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 8 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс зориулалт бусаар зарцуулсан 10.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, анхан шатны баримтад и-баримтын бүрдэл дутуу, татвар, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнах, тооллогын тайланг иж бүрэн ирүүлэх, цалин, хөлс баталсан тушаалд нэмэгдлийг хамт баталж хэвших, ур чадварын нэмэгдлийг журмын дагуу олгох, хөрөнгийг зөв ангилж данс бүртгэлд тусгах, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үнэн зөв тооцоолох, шилэн дансны хуулийн

хэрэгжилтийг хангаж ажиллах гэх мэт 8.6 сая төгрөгийн 8 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 449.6 сая төгрөгийн 141 нэр төрлийн 2233 хөрөнгө байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн ЗДТГ-аас 75.0 сая төгрөгийн 22 ширхэг зөөврийн компьютер, хандиваар 5.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 68.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын цалингийн зардал 1,581.8 сая төгрөг бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 1,485.7 сая төгрөгөөр, татварын байгууллагад 1,480.4 сая төгрөгөөр тус тус тайлагнасан. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 442.5 сая төгрөгийн 22 гүйлгээг байршуулсан ба орлогын нийт 2,379.1 сая төгрөгийн 66 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулах тушаал, шийдвэрийг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна.

Өмнөх оны аудитыг Есөнхангай аудит ХХК гүйцэтгэж тус аудитаар 28.4 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 8 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс зориулалт бусаар зарцуулсан 10.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, анхан шатны баримтад и-баримтын бүрдэл дутуу, татвар, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнах, тооллогын тайланг иж бүрэн ирүүлэх, цалин, хөлс баталсан тушаалд нэмэгдлийг хамт баталж хэвших, үр чадварын нэмэгдлийг журмын дагуу олгох, хөрөнгийг зөв ангилж данс бүртгэлд тусгах, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үнэн зөв тооцоолох, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах гэх мэт 8.6 сая төгрөгийн 8 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 449.6 сая төгрөгийн 141 нэр төрлийн 2233 хөрөнгө байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	372,034,326.23	474,011,937.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	132,308,716.44	204,301,677.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	132,308,716.44	204,301,677.99
3121	Төгрөг	132,308,716.44	204,301,677.99
31211	Төрийн сангийн харилцах	132,308,716.44	204,301,677.99
33	АВЛАГА	2,400,000.00	-
335	Бусад авлага	2,400,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	2,400,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	237,325,609.79	269,710,259.05
351	Түүхий эд материал	1,346,600.00	1,947,540.00
35110	Тусгай зориулалттай материал	960,000.00	1,510,000.00
35130	Эм боох материал	386,600.00	437,540.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	1,132,350.00
354	Хангамжийн материал	235,979,009.79	266,630,369.05
35410	Бичиг хэргийн материал	15,824,132.00	23,895,117.00
35420	Аж ахуйн материал	70,301,718.94	89,112,537.20
35450	Барилгын засварын материал	-	112,090.00
35460	Хүнсний материал	-	29,800.00
35470	Бусад хангамжийн материал	149,853,158.85	153,480,824.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,871,221,737.10	1,882,118,240.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,871,221,737.10	1,882,118,240.63
392	Биет хөрөнгө	1,666,694,070.22	1,678,022,323.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,669,362,566.00	1,669,362,566.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(286,441,849.80)	(358,053,581.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	438,640,550.40	586,780,550.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(305,423,882.88)	(358,011,490.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	228,493,487.35	230,893,487.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(185,898,968.66)	(204,377,396.84)
39209	Зам, гүүрийн байгууламж	97,723,671.06	97,723,671.06
39210	Хуримтлагдсан элэгдэл	(92,569,026.93)	(93,170,468.13)
39217	Ном	102,807,523.68	106,874,985.18
393	Биет бус хөрөнгө	204,527,666.88	204,095,916.96
39301	Програм хангамж	3,077,000.00	3,077,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,501,333.12)	(2,933,083.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	203,952,000.00	203,952,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,243,256,063.33	2,356,130,177.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	22,545,717.02
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	22,545,717.02
413	Өглөг	-	22,545,717.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	22,545,717.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,243,256,063.33	2,333,584,460.65
51	Засгийн газрын хувь оролцоо	2,243,256,063.33	2,333,584,460.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,498,640,057.09	2,498,640,057.09
51102	- төрийн	2,498,640,057.09	2,498,640,057.09
512	Хуримтлагдсан үр дүн	(879,139,833.56)	(788,811,436.24)
51210	Өмнөх үеийн үр дүн	(879,139,833.56)	(879,139,833.56)
51220	Тайлант үеийн үр дүн	-	90,328,397.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	623,755,839.80	623,755,839.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,243,256,063.33	2,356,130,177.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,355,487,294.22	2,502,745,229.66

Сайншанд сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,069,082.00	104,822,235.76
120	Нийтлэг татварын бус орлого	24,069,082.00	104,822,235.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,069,082.00	104,822,235.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,085,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,100,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	19,866,934.00	84,227,461.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	4,202,148.00	7,408,874.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,331,418,212.22	2,397,922,993.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,018,696,800.00	2,103,632,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,018,696,800.00	2,103,632,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,809,125.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,799,125.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,010,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	308,912,287.22	294,290,593.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,912,287.22	294,290,593.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,268,982,062.56	2,412,416,832.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,268,982,062.56	2,412,416,832.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,118,733,764.56	2,281,203,132.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,358,587,899.99	1,590,795,318.75
210101	Үндсэн цалин	1,033,649,434.52	1,066,110,013.73
210102	Нэмэгдэл	305,973,155.47	439,668,076.41
210104	Урамшуулал	18,965,310.00	85,017,228.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,011,901.69	191,375,752.72
210201	Тэтгэврийн даатгал	176,757,860.30	128,802,460.45
210202	Тэтгэмжийн даатгал	15,091,502.84	15,313,717.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,676,798.69	12,801,540.35
210204	Ажилгүйдлийн даатгал	2,950,917.79	3,191,191.13
210205	Эрүүл мэндийн даатгал	32,534,822.07	31,266,842.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	267,391,195.22	282,323,429.90
210301	Гэрэл, цахилгаан	12,090,205.22	15,773,867.90
210302	Түлш, халаалт	226,906,710.00	250,312,986.00
210303	Цэвэр, бохир ус	28,394,280.00	16,236,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,495,479.00	10,000.00
210401	Бичиг хэрэг	1,105,309.00	10,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,390,170.00	-
2105	Нормативт зардал	609,550.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	609,550.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,108,785.00	2,861,760.00
210604	Урсгал засвар	14,108,785.00	2,861,760.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,279,200.00	17,948,832.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,410,000.00	9,085,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,869,200.00	8,862,932.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,249,753.66	195,888,038.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,448,147.00	33,991,029.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,482,475.00	18,186,052.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,319,131.66	143,710,957.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,248,298.00	131,213,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,248,298.00	131,213,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	148,248,298.00	128,413,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	86,505,231.66	90,328,397.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	86,505,231.66	90,328,397.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,353,890,099.22	2,411,108,893.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,413,533.00	13,185,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,413,533.00	13,185,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,413,533.00	13,185,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,466,333.00	9,085,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,947,200.00	4,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,342,476,566.22	2,397,922,993.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,018,696,800.00	2,103,632,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,018,696,800.00	2,103,632,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,867,479.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,799,125.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,068,354.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	308,912,287.22	294,290,593.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,912,287.22	294,290,593.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,148,008,081.90	2,271,135,932.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,148,008,081.90	2,271,135,932.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,995,342,483.90	2,139,892,432.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,396,720,361.90	1,581,843,238.22
210101	Үндсэн цалин	1,029,948,752.43	1,066,110,013.73
210102	Нэмэгдэл	334,076,322.47	439,668,076.41
210104	Урамшуулал	32,695,287.00	76,065,148.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,879,439.78	177,632,116.23
210201	Тэтгэврийн даатгал	136,919,941.63	115,058,823.96
210202	Тэтгэмжийн даатгал	16,157,000.00	15,313,717.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,911,456.26	12,801,540.35
210204	Ажилгүйдлийн даатгал	3,171,157.03	3,191,191.13
210205	Эрүүл мэндийн даатгал	31,719,884.86	31,266,842.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	267,391,195.22	282,323,429.90
210301	Гэрэл, цахилгаан	12,090,205.22	15,773,867.90
210302	Түлш, халаалт	226,906,710.00	250,312,986.00
210303	Цэвэр, бохир ус	28,394,280.00	16,236,576.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,992,995.00	11,967,164.00
210604	Урсгал засвар	7,992,995.00	11,967,164.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,226,400.00	18,098,832.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,947,200.00	9,085,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,279,200.00	9,012,932.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,132,092.00	68,027,652.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,644,523.00	42,428,755.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,487,569.00	25,598,897.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,665,598.00	131,243,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	152,665,598.00	131,243,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	150,665,598.00	128,443,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	205,882,017.32	139,972,961.55
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	73,573,300.00	67,980,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,573,300.00	67,980,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	73,573,300.00	67,980,000.00
222001	Тоног төхөөрөмж	73,073,300.00	67,980,000.00
223001	Бусад хөрөнгө	500,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(73,573,300.00)	(67,980,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	132,308,717.32	71,992,961.55

Сайншанд сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		132,308,716.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132,308,716.44	204,301,677.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(879,139,833.56)	2,243,256,063.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(879,139,833.56)	2,243,256,063.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	110,313,125.25	110,313,125.25
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(768,826,708.31)	2,353,569,188.58
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(768,826,708.31)	2,353,569,188.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(768,826,708.31)	2,353,569,188.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	90,328,397.32	90,328,397.32
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(678,498,310.99)	2,443,897,585.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,727,335,100.00	2,339,115,932.35	388,219,167.65	85.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,727,335,100.00	2,339,115,932.35	388,219,167.65	85.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,570,721,900.00	2,207,872,432.35	362,849,467.65	85.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,841,544,100.00	1,581,843,238.22	259,700,861.78	85.90
210101	Үндсэн цалин	1,250,169,000.00	1,066,110,013.73	184,058,986.27	85.28
210102	Нэмэгдэл	514,286,600.00	439,668,076.41	74,618,523.59	85.49
210104	Урамшуулал	77,088,500.00	76,065,148.08	1,023,351.92	98.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,192,900.00	177,632,116.23	52,560,783.77	77.17
210201	Тэтгэврийн даатгал	156,531,200.00	115,058,823.96	41,472,376.04	73.51
210202	Тэтгэмжийн даатгал	18,415,400.00	15,313,717.99	3,101,682.01	83.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,732,300.00	12,801,540.35	1,930,759.65	86.89
210204	Ажилгүйдлийн даатгал	3,683,100.00	3,191,191.13	491,908.87	86.64
210205	Эрүүл мэндийн даатгал	36,830,900.00	31,266,842.80	5,564,057.20	84.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	309,903,400.00	282,323,429.90	27,579,970.10	91.10
210301	Гэрэл, цахилгаан	18,500,000.00	15,773,867.90	2,726,132.10	85.26
210302	Түлш, халаалт	258,843,400.00	250,312,986.00	8,530,414.00	96.70
210303	Цэвэр, бохир ус	32,560,000.00	16,236,576.00	16,323,424.00	49.87
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	11,967,164.00	32,836.00	99.73
210604	Урсгал засвар	12,000,000.00	11,967,164.00	32,836.00	99.73

Сайншанд сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,508,900.00	18,098,832.00	8,410,068.00	68.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,379,100.00	9,085,900.00	293,200.00	96.87
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,129,800.00	9,012,932.00	8,116,868.00	52.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,572,600.00	136,007,652.00	14,564,948.00	90.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,877,900.00	110,408,755.00	14,469,145.00	88.41
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,694,700.00	25,598,897.00	95,803.00	99.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,613,200.00	131,243,500.00	25,369,700.00	83.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	156,613,200.00	131,243,500.00	25,369,700.00	83.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	156,613,200.00	128,443,500.00	28,169,700.00	82.01
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,800,000.00	(2,800,000.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,727,335,100.00	2,411,108,893.90	316,226,206.10	88.41
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,243,948,900.00	2,103,632,400.00	140,316,500.00	93.75
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,243,948,900.00	2,103,632,400.00	140,316,500.00	93.75
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	296,312,300.00	294,290,593.90	2,021,706.10	99.32
132001	Орон нутгийн төсвөөс	296,312,300.00	294,290,593.90	2,021,706.10	99.32
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,279,100.00	13,185,900.00	93,200.00	99.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,085,900.00	(9,085,900.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,279,100.00	4,100,000.00	9,179,100.00	30.88
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		132,308,716.44	(132,308,716.44)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		204,301,677.99	(204,301,677.99)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	85.00	84.00	1.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	58.00	1.00	-
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00	-	-

Аудит хийсэн ахмадын сангийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		0.00
120	Нийтлэг татварын бус орлого		0.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		0.00
1200001	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		0.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,800,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-2,800,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-2,800,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,271,425.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,471,425.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13.1 сая төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс аудитын явцад 13.1 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Тайлант онд нийт 5,651.9 мянган төгрөгийн шуудан холбоо болон интернетийн төлбөрийг мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд бүртгэснийг залруулав.
2. Тайлант онд шинээр худалдан авсан тус бүр нь 480.0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг бичгийн шүүгээний нийт 250.0 мянган төгрөгийн элэгдлийг бодуулаагүй байна.
3. Тус байгууллага нь тайлант хугацааны орлогыг нийгмийн даатгалаас төлөх ХЧТАТ-ийн орлого болох 55.5 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор бүртгэж тайлагнасан байна.
4. Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан Улсын төсвөөс санхүүжих санхүүжилтийг 650.0 мянган төгрөгөөр илүү, үндсэн болон туслах, үйл ажиллагааны орлогыг 2,461.8 мянган төгрөгөөр дутуу тусгасныг залруулав
5. Боловсрол, шинжлэх ухааны газраас хуваарилсан 2,049.5 мянган төгрөгийн үнэ бүхий номыг үндсэн хөрөнгөд орлого аваагүй ба 2,018.0 мянган төгрөгийн номыг бараа материалын дансанд орлого авсныг залруулав.

Аудитаар нийт 3 зөрчил² илэрснээс, 22.5 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлагналтай холбоотой асуудал

Тус байгууллагын цалингийн зардал 1,581.8 сая төгрөг бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 1,485.7 сая төгрөгөөр, татварын байгууллагад 1,480.4 сая төгрөгөөр тус тус тайлагнасан. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 25 дугаар зүйлийн 25.1.1-д “энэ хуулийн 14 дэх зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-т “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх” заалтуудтай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 442.5 сая төгрөгийн 22 гүйлгээг байршуулсан ба орлогын нийт 2,379.1 сая төгрөгийн 66 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулах тушаал, шийдвэрийг шилэн дансны цахим системд огт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байршуулаагүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Өмнөх оны аудитыг Есөнхангай аудит ХХК гүйцэтгэж тус аудитаар 28.4 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 8 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс зориулалт бусаар зарцуулсан 10.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, анхан шатны баримтад и-баримтын бүрдэл дутуу, татвар, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнах, тооллогын тайланг иж бүрэн ирүүлэх, цалин, хөлс баталсан тушаалд нэмэгдлийг хамт баталж хэвших, үр чадварын нэмэгдлийг журмын дагуу олгох, хөрөнгийг зөв ангилж данс бүртгэлд тусгах, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үнэн зөв тооцоолох, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах гэх мэт 8.6 сая төгрөгийн 8 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 449,592,785.09 төгрөгийн 141 нэр төрлийн 2233 хөрөнгө байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, 31.3.3 “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Үр дагавар: хөрөнгө үнэгүйдэх, дутагдах үр дагавартай.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, эсхүл дахин шинээр үнэлгээ тогтоон цаашид ашиглах асуудлыг шийдвэрлэх.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайлангийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй.	1	5,651.9			1	5,651.9	1	5,651.9				
Үндсэн хөрөнгийн элэгдэл бодуулаагүй	1	250.0			1	250.0	1	250.0				
Нийгмийн даатгалын байгууллагаас төлөх ХЧТАТ-ийг мөнгөн гүйлгээний тайланд орлогоор бүртгэсэн	1	55.5			1	55.5	1	55.5				
Санхүүжилт болон үндсэн үйл ажиллагааны орлогыг буруу бүртгэж тайлагнасан	1	3,111.8			1	3,111.8	1	3,111.8				
Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй болон бараа материалын дансанд орлого авсан	1	4,067.5				4,067.5		4,067.5				
Дүн	5	13,136.8			5	13,136.8	5	13,136.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 442.5 сая төгрөгийн 22 гүйлгээг байршуулсан ба орлогын нийт 2,379.1 сая төгрөгийн 66	1		-	-	1	-	-	

Сайншанд сумын ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулах тушаал, шийдвэрийг шилэн дансны цахим системд огт байршуулаагүй байна.									
Дүн	1	-	-	1	-	-			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тохируулах бичилтийг буруу хийснээс үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал алдаатай илэрхийлэгдэж 13,480,695.99 төгрөгийн НДШ, 9,065,021.03 төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөрийг орхигдуулсан байна.	1	22,545.7	-	-	1	22,545.7	-	-	-	-	-	-
Өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй	1	-			1	-						
Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 449,592,785.09 төгрөгийн 141 нэр төрлийн 2233 хөрөнгө байна.	1	-		-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	3	22,545.7	-	-	2	22,545.7	1	-				